


“Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайлангийн маягтыг бэлтгэх, тайлагнахад анхаарах зөвлөмж

Сонгуулийн зардлын тайланг бэлтгэх үйл явцын зураглал болон маягт хоорондын уялдаа, хамаарлыг дараах байдлаар хянаж баталгаажуулна. Үүнд:

1. Сонгуулийн зардлын тайланг бэлтгэх үйл явцын зураглал



2. Батлагдсан маягтын уялдаа, харилцан хамаарлыг шалгах:

2.1. Нам, эвслийн сонгуулийн зардлын хураангуй тайлангийн /маягт 1.1, 1.2/ сонгуулийн үр дүнгийн тайлангийн мөнгөн дүнгүүд нь бусад маягтуудын мөнгөн дүнтэй дараах байдлаар уялдаа, харилцан хамааралтай байна. Үүнд:

1. Нийт орлого дүн:

- 1.1. Намын өөрийн хөрөнгийн дүн нь “Маягт 8”-ын 7 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 1.2. Хуулийн этгээдийн хандивын дүн нь “Маягт 8”-ын 11, 12 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 1.3. Иргэний хандивын дүн нь “Маягт 8”-ын 9, 10 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

2. Нийт зардлын дүн:

- 2.1. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 7, 8 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 9 дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 10 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 11 дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.5. Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 12-16 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 17 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.7. Цахим орчин ашиглах зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 19-21 дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 2.8. Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд материал нийтлүүлэх зардлын мөнгөн дүн нь “Маягт 9”-ийн 18 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

3. Үлдэгдлийн мөнгөн дүн нь харилцах дансны үлдэгдэлтэй /дансны хуулгаар/ тэнцүү байна.

4. Төлөгдөөгүй байгаа өр төлбөрийн дүн нь “Маягт 7”-ын төлөх дүнтэй тэнцүү байна. Жич: Өр төлбөр нь бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

5. Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын дүн нь “Маягт 5”-ын хандивын хэмжээний нийт дүнтэй тэнцүү байна.

2.2. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хураангуй тайлангийн /маягт 1.3/ сонгуулийн үр дүнгийн тайлангийн мөнгөн дүнгүүд нь бусад маягтуудын мөнгөн дүнтэй дараах байдлаар уялдаа, харилцан хамааралтай байна. Үүнд:

1. Намын өөрийн хөрөнгийн дүн нь “Маягт 8”-ын 7 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
2. Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн дүн нь “Маягт 8”-ын 8 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
3. Хуулийн этгээдийн хандивын дүн нь “Маягт 8”-ын 11,12 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
4. Иргэний хандивын дүн нь “Маягт 8”-ын 9, 10 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

Нийт зардал, харилцах дансны үлдэгдэл, төлөгдөөгүй байгаа өр төлбөр, хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын мөнгөн дүнгүүдийн уялдаа нь дээрх Маягт 1.1, 1.2-ын уялдаа, хамааралтай адилхан байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хураангуй тайлангийн (маягт 1.1, 1.2, 1.3) орлого, зарлагын бүх мэдээлэл нь дансны хуулгаар баталгаажсан байна.

2.3. Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн тайлангийн “Маягт 2”-ын мөнгөн дүн нь “Маягт 8”-ын нам, эвслийн өөрийн хөрөнгө 7, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө 8 дугаар баганын дүнтэй тус тус тэнцүү байна. Дансны дугаар, банкны нэр гэсэн баганад нам, эвсэл, нэр дэвшигчийн ямар данснаас шилжүүлсэн талаарх мэдээллийг оруулна.

2.4. Мөнгөн хандивын тайлангийн “Маягт 3”-ын хандивын хэмжээ нь “Маягт 8”-ын 9, 11 дүгээр баганын дүнтэй тэнцүү байна.

Жич: Энэ маягтад хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг оруулахгүй бөгөөд хандивын талаарх мэдээллийг “Маягт 5”-д оруулна.

2.5. Мөнгөн бус хандивын тайлангийн “Маягт 4”-ийн хандивын хэмжээ нь “Маягт 8”-ын 10, 12 дугаар баганын дүнтэй тэнцүү байна. Энэ маягтад хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг оруулахгүй бөгөөд хандивын талаарх мэдээллийг “Маягт 5”-д оруулна. Мөн энэ маягтын 5 дахь баганад бусад хөдлөх эд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгийг эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

Жич: Энэ маягтад хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг оруулахгүй бөгөөд хандивын талаарх мэдээллийг “Маягт 5”-д оруулна.

2.6. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайланд (Маягт 5) “маягт 8”-ын 9-12 дугаар багана дахь хандивын талаарх мэдээллээс хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын талаарх мэдээллийг энэ маягтад хуримтлуулж бүртгэнэ.

2.7. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаасан буюу улсын орлого болгосон тухай тайланд (Маягт 6) “маягт 9”-ын 22 дугаар багана дахь мэдээллээс энэ маягтад хуримтлуулж бүртгэнэ.

2.8. Сонгуулийн зардалтай холбоотой өглөгийн тайланд (“Маягт 7”) тусгагдсан төлөх дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.

2.9. Сонгуулийн зардлын дансны орлогын дэлгэрэнгүй тайлангийн “Маягт 8”-ын 7 дугаар баганын нийт дүн нь Маягт 2-ын мөнгөн дүнтэй тэнцүү байна. Мөн 8 дугаар баганын мэдээлэл энд хамаарна.

Сонгуулийн зардлын дансны орлогын дэлгэрэнгүй тайлангийн “Маягт 8”-ын 9 дүгээр баганын мэдээллийг “Маягт 3”-ын “иргэн” хэсэгт оруулна. Энэ маягтын 9 дүгээр баганын дүн нь “Маягт 3”-ын “иргэн” хэсгийн хандивын хэмжээ болон “Маягт 5” дахь хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын хэмжээтэй тэнцүү байна. Энэ маягтын “мөнгөн бус хандив” гэсэн багана нь ижил зарчимтай хийгдэнэ.

Энэ маягтын 11 дүгээр баганын мэдээллийг “Маягт 3”-ын “хуулийн этгээд” хэсэгт оруулна. Энэ маягтын 11 дүгээр баганын дүн нь “Маягт 3”-ын “хуулийн этгээд” хэсгийн хандивын хэмжээ болон “Маягт 5” дахь хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын хэмжээтэй тэнцүү байна.

Энэ маягтын мөнгөн бус хандив гэсэн багана нь ижил зарчимтай хийгдэнэ.

Орлогын нийт дүн 7-15 дугаар баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байх ёстой.

Жич: Орлогын бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна.

2.10. Сонгуулийн зардлын дансны зарлагын дэлгэрэнгүй тайлангийн “Маягт 9”-ийн 22 дугаар багана дахь зардлын ангилалд энэ маягтын 7-21 дүгээр багануудад тусгагдаагүй хамаарахгүй зардлыг энд хуримтлуулан бүртгэж, зохих тодруулга, тайлбарыг тусгана.

Зарлагын нийт дүн 7-22 дугаар баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байх ёстой.

Жич: Зарлагын бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна.